



## ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРТ ГАДААДЫН ЗЭЭЛ, ТУСЛАМЖИЙН ХӨРӨНГӨӨР ХЭРЭГЖИЖ БАЙГАА ТӨСЛҮҮДЭД 2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР ХЯНАЛТ- ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН

2023.02.27

Улаанбаатар хот

### Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, арга зүй

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслүүдэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ хийж үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар зөвлөмж боловсруулан, хэрэгжилтийн үр дүн, хариуцлагыг сайжруулахад энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго оршино.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус баримталсан.

### Хоёр. Хамарсан хүрээ

Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр зам, тээврийн салбарт 6 төслийн хүрээнд хэрэгжсэн 10 арга хэмжээг хамруулан 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

### Гурав. Үнэлгээ

Хүснэгт 1

№	Төслийн нэр	Арга хэмжээний нэр	2022 оны үнэлгээ	Төслийн хэрэгжилт
<b>Авто замын салбарт:</b>				
1	Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2”	Баруун бүсийн босоо тэнхлэгийн АН-4 чиглэлийн авто замын трассын дагуу баригдах 189.7 км хатуу хучилттай авто зам (Багц CW1-1, Багц CW1-2, Багц CW1-3, CW1-4 хэсгүүд)	95 хувь	96.5 хувь
2	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй төсөл	“Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам”	100 хувь	100 хувь



3	Монгол Улсын Засгийн газар болон Европын сэргээн босголт, хөгжлийн банк хооронд байгуулсан “Улаанбаатар-Дархан чиглэлийн авто замын өргөтгөлийн төсөл”	Улаанбаатар-Дархан чиглэлийн 202,42 км авто замын шинээр баригдах өргөтгөлийн төсөл	65 хувь	60,5 хувь
4	Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй “Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл”	Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил	84,9 хувь	83 хувь
		Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажил	-	-
		Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засвар	100 хувь	85.8 хувь
<b>Төмөр замын салбарт:</b>				
5	“Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь” төсөл		30 хувь	30 хувь (Судалгааны ажил үргэлжилж байна).
	МОН ТА 8935: Богдхан тойруу төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөл	Франц Улсын “Систра” компани болон Монгол Улсын “Эм Си Пи, Си Жи Ар” компанийн нэгдлээс төслийн Англи, Монгол хэл дээрх эцсийн шатны тайлан боловсруулах.	100 хувь	100 хувь
	“Монгол Улсын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (ГТХЗНТ)-ийн барилга барих, түүний үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх” төсөл		30 хувь	30 хувь (БНСУ-ын Олон Улсын хамтын ажиллагааны байгууллага, Зам, тээврийн хөгжлийн яам, “Эм Эс Эл” ХХК, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” УТҮГ хамтарсан гэрээ байгуулсан).
<b>Иргэний нисэхийн салбарт:</b>				
6	Хэнтий аймгийн “Өндөрхаан нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”	Багц-1 барилга байгууламжийн ажил, Багц-2 аэродромын ажил гүйцэтгэх	38 хувь	66 хувь
<b>Авто тээврийн салбарт:</b> Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр тус салбарт 2022 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ байхгүй.				
<b>Дундаж үнэлгээ</b>			<b>71.4 хувь</b>	<b>72.4 хувь</b>



## Дөрөв. Дүгнэлт

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр зам, тээврийн салбарт 6 төслийн хүрээнд 10 арга хэмжээ хэрэгжүүлсэн. Эдгээр арга хэмжээнүүдэд 2022 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд 71.4 хувийн хэрэгжилттэй байна. Энэ нь өмнөх оныхоос 10.3 хувийн өсөлттэй байна.
2. Дархан- Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын засварын ажлын сонгон шалгаруулалтыг 2023 онд хийхээр төлөвлөсөн тул үнэлгээнд оруулаагүй.

## Тав. Тулгамдаж буй асуудал

### Иргэний нисэхийн салбарт:

Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хэнтий аймгийн “Өндөрхаан онгоцны нисэх буудлыг шинэчлэн барих төсөл”-ийн хувьд дараах тулгамдсан асуудлууд байна. **Үүнд:**

1. Төсөл хэрэгжүүлэх нэгжийн үйл ажиллагаанд ашиглагдаж байсан УНЭ 77-49 улсын дугаартай автомашиныг “Монголын төмөр зам” ТӨХК-нд 2022 оны 05 дугаар сарын 03-нд шилжүүлснээс хойш одоог хүртэл автомашинтай болж чадаагүй байна. Үүнээс үүдэн төслийн барилга угсралтын ажилд мэргэжлийн хяналт тавьж чадахгүй нөхцөл, байдал үүссээр байна.
2. Санхүүжилтийн гүйцэтгэл удааширсан. Багц-1 барилгын ажлын гүйцэтгэгчийн эхний санхүүжилтийн гүйцэтгэл 121 хоногийн дараа, багц-2 аэродромын ажлын гүйцэтгэгчийн 5 дахь санхүүжилтийн гүйцэтгэл 109 хоногийн дараа гүйцэтгэгчийн дансанд тус тус орсон.
3. Барилгын материалын үнийн өсөлт, цементийн хомсдолоос шалтгаалж барилгын ажил удаашралтай явагдсан.
4. Барилгын чанарын баталгааны 5 хувийг аль байгууллагын дансанд байршуулах нь тодорхой бус байна.
5. Аванперрон болон перроны хөвөөний ажил, гүний худгийн өрөмдлөгийн ажил төсөвт тусгагдаагүй бөгөөд магадлашгүй ажлын зардлаар хийж гүйцэтгэх төлөвлөгөөтэй байна.
6. Аэродромын ажлын гүйцэтгэгч, Хэрлэн сумын ЗДТГ хооронд орон нутгийн түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөрийн асуудлаар маргасаар аэродромын нислэгийн зурвасны (2800x150м талбай) перроны хөвөөний тэгшилгээний ажил дуусаагүй.
7. Перроны бетон хучилтын зарим засварын ажил цаг агаар хүйтэрсэн тул зогссон.

### Авто замын салбарт:

1. Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын хяналтын зөвлөх үйлчилгээний ажлын хувьд “Зам барилгын ажлын гүйцэтгэгчийн гэрээний хугацааг сунгасантай холбогдуулан зөвлөхийн гэрээнд заасан инженер техникийн ажилчдын хүн сарын зардал дуусч байгаатай холбогдуулан гэрээнд өөрчлөлт оруулах саналыг санхүүжүүлэгч банктэй зөвшилцөж, шийдвэрлэх шаардлагатай”;

2. Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын багц 1 дүгээр хэсэг буюу “Баруун аймаг салах тойрог уулзвараас Хар модот давааны ар хүртэлх 37.26 км авто зам барих төсөл”-ийн хувьд “Азийн хөгжлийн банкны төслийн замын хоёр талаар өргөсгөл бүхий 22 км авто замын хэсгийн өнгө асфальтбетон хучилтын ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу 2023 оны 06 дугаар сард багтаан дуусгаж, Европын сэргээн босголтын банкны төслийн замын гүйцэтгэгчид асфальт бетон хучилтын ажлаа саадгүй хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай. Иймд тухайн Азийн хөгжлийн банкны төслийн багц 1-р хэсгийн нэмэлт 5 см асфальтбетон хучилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулах”;
3. Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын багц 2 дугаар хэсэг буюу “Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто зам барих төсөл”-ийн хувьд “Тухайн зам барилгын ажил 2022 онд батлагдсан график төлөвлөгөөнөөс 39.9 хувийн хоцрогдолтой хэрэгжсэн тул барилгын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай”;
4. Улаанбаатар-Дархан чиглэлийн шинээр баригдах 2 эгнээ авто замын багц 3 дугаар хэсэг буюу “Урьханаас Сүмбэрийн уулзвар хүртэлх 45.74 км авто зам барих төсөл”-ийн хувьд “Зам барилгын ажил 2022 онд батлагдсан график төлөвлөгөөнөөс 39 хувийн хоцрогдолтой хэрэгжсэн тул барилгын ажлыг эрчимжүүлэх”;
5. Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажлын хувьд “багц 1-1 хэсгийн гэрээг цуцлах шийдвэрийг 2023 оны 02 сарын 01-ний өдөр баталгаажуулж Азийн хөгжлийн банкнаас зөвшөөрөл авахаар хүсэлтээ хүргүүлсэн. Тус багцын гүйцэтгэлийг одоогийн байгаа байдлаар нь хүлээн авч, нэмэлт 5 см асфальтбетон хучилтын тендерт нэмэлтээр оруулах төлөвлөгөөтэй байгаа. Багц 1-3 хэсгийн нэмэлт 5см асфальтбетон хучилтын тендерийн сонгон шалгаруулалтын материалын бэлтгэл ажил удаашралтай байгаа ба гүйцэтгэгч компаниар үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх боломжийг судлан ажиллах;
6. “Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төсөл 2-ын хувьд “Төслийн 3129-МОН зээлийн гэрээг дахин сунгахгүй бөгөөд 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдөр дуусгавар болгохтой холбоотойгоор Ховд-Баян-Өлгий чиглэлийн авто замаас Эрдэнэбүрэн сум чиглэлийн 19.776 км зам болон Ховд сум чиглэлийн 18.775 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг шуурхай зохион байгуулж, ажлыг 2023 ондоо багтаан дуусгах”;
7. Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 57.56 км авто замын барилгын ажлын хувьд “Онги голын гүүрний урсгал засварын зардал нь тус төслийн зардалд тусгагдсан боловч Мэргэжлийн хяналтын ерөнхий газар болон зөвлөх компани, зураг төслийн компанийн хийж гүйцэтгэсэн шалгалтын үеэр тус гүүрэнд их засвар хийх шаардлагатай ба тус гүүр нь нурах, замын хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөх өндөр магадлалтай байгаа талаар дүгнэлт гаргасан. Үүнтэй холбоотойгоор тус гүүрийн их засварын ажлын зураг төсөл гүйцэтгүүлэх болон түр зам угсралтын ажлыг гүйцэтгэгч компаниар хийлгэхээр төлөвлөн ажиллаж байна”;

## Зургаа. Төслийн үр дүн

Зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2022 онд дээрх төслүүд хэрэгжсэнээр дараах эерэг үр дүнг үзүүлсэн байна. **Үүнд:**

1. Азийн авто замын сүлжээний АН-32 чиглэл буюу Мянганы замын хэвтээ тэнхлэгийн нэг хэсэг болох Завхан аймгийн төвийг нийслэл хоттой холбох Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км авто зам нь Завхан аймаг дахь хамгийн хүнд, бэрхшээлтэй нөхцөлд тооцогдох Монгол орны Тарвагатайн нурууны хүндрэлтэй даваа болох далайн түвшнээс дээш 2500 метрийн өндөрт байрлах Загастайн даваагаар 40 гаруй киломтер дайран өнгөрдөг уулын зам бөгөөд авто замын салбарт өмнө нь уулын өндөр хавцал, хясаатай хүнд нөхцөлд тооцогдох ийм хэмжээний урт үргэлжилжилсэн зам баригдаж байгаагүй тул дээрх туршлага, ур чадварыг авто замчид эзэмшиж чадлаа.
2. Энэхүү 67 км авто зам ашиглалтад орсноор Монгол орны бүх аймгийн төв нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар бүрэн холбогдсон.
3. Төслийн хүрээнд шинээр авто замууд үргэлжлэн баригдсанаар Монгол Улсын авто замын сүлжээний урт нэмэгдэж, ард иргэд тав тухтай, түргэн шуурхай зорчих боломж бүрдэж, гадаад болон дотоодын аялагч жуулчдын тоо нэмэгдэх, цаашлаад тухайн бүс нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийг түргэтгэн, үйлдвэрлэл үйлчилгээг хөгжүүлэх боломжийг бүрдүүлж өгсөн.
4. Зам, тээврийн салбарын мэргэжлийн компаниуд дээрх төслүүдэд ерөнхий болон туслан гүйцэтгэгчээр ажилласнаар инженер техникийн болон мэргэжлийн ажилчдын ур чадвар, туршлага нэмэгдэж, үндэсний аж ахуйн нэгжүүдийн чадавх сайжирч байна.

## Долоо. Санал, зөвлөмж, цаашид анхаарах асуудал

1. Зам, тээврийн салбарт гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр 2023 онд үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээнүүдийг хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэхэд чиглэсэн зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх;
2. Төсөл, арга хэмжээнүүдэд “Гадаадаас авч ажиллуулах ажиллах хүчний зөвшөөрөл”-ийг холбогдох байгууллагууд цаг алдалгүй гаргаж, ажлыг төлөвлөгөөний дагуу хэрэгжих нөхцлийг бүрдүүлэх;
3. Барилга, угсралтын ажлын гүйцэтгэл бичигдэж, батлагдсан тухай бүрд санхүүжилтийг хугацаанд нь саадгүй олгох талаар санхүүжүүлэгч байгууллага, Сангийн яамтай хамтарч ажиллах зэрэг болно.

## ТАНИЛЦСАН:

САЙД

С.БЯМБАЦОГТ

ДЭД САЙД

Л.ХАЛТАР



ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГА

Ц.ОДХҮҮ

**ХЯНАСАН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА

А.МӨНХБАТ

**НЭГТГЭСЭН:**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД  
АУДИТЫН ГАЗРЫН ШИНЖЭЭЧ

Б.ГАНТӨМӨР

---

Энэхүү тайланд тусгагдсан арга хэмжээнүүдтэй холбоотой нэмэлт болон нарийвчилсан мэдээллийг дараах байдлаар авна уу.

1. Азийн хөгжлийн банкны зээлээр хэрэгжиж буй "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх, засвар арчлалтын төсөл"-ийн хүрээнд хэрэгжиж буй Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.11 км авто замын өргөтгөл шинэчлэлтийн ажил, Дархан-Алтанбулаг чиглэлийн 118 км авто замын аюулгүй байдлыг хангах засвар, арчлалтын ажил, Хүйтний хөндий-Арвайхээр чиглэлийн 58 км авто замын их засварын ажилтай холбоотой мэдээллийг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч Н.Мөнхбаясгалан (99110302), төслийн ажилтан Д.Галбадрах (80080985);
2. Европын сэргээн босголт, хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Улаанбаатар-Дархан чиглэлийн 202.4 км авто замын өргөтгөлийн төсөл", БНХАУ-ын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжиж буй "Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 67 км хатуу хучилттай авто зам"-ын ажилтай холбоотой мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Ууганбаяр (99031472);
3. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжиж буй "Баруун бүсийн босоо тэнхлэгийн авто замыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын хөтөлбөр төсөл-2"-той холбоотой мэдээллийг Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зохицуулагч н.Баян-Амгалан, төслийн ажилтан н.Оюун (99094262);
4. Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Хэнтий аймгийн "Өндөрхаан онгоцны нисэх буудлыг шинэчлэн барих төсөл"-тэй холбоотой мэдээллийг ТХН-ийн Хяналт шинжилгээ, үнэлгээний ажилтан С.Байгалмаа (99048519)
5. "Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (ЕARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь", MON TA 8935: Богдхан тойруу төмөр замын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлж буй Богдхан төмөр зам төслийн техник, эдийн засгийн урьдчилсан судалгаа боловсруулах зөвлөх үйлчилгээний төсөл, "Монгол Улсын Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв (ГТХЗНТ)-ийн барилга барих, түүний үйл ажиллагааны чадавхыг бэхжүүлэх замаар Монгол Улсын төмөр замын өрсөлдөх чадварыг дээшлүүлэх" төсөлтэй холбоотой мэдээллийг Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын мэргэжилтэн Б.Нарантунгалаг (9918-3957);